

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САРАНСҮХ

2022.02.22

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2019-2022 ОНЫ ӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

АЖЛЫН ЗОРИЛГО:

“Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүн”-д хийх аудитын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын өрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулах, аудитын багт мэргэжлийн тусалцаа үзүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

Эхлэх хугацаа: 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр

Дуусах хугацаа: 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр

Байршил: Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, Өрийн удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэнэ.

ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитад Монгол Улсын Засгийн газрын 2019-2021 оны өрийн нөхцөл байдал, түүнд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлсийн судалгаа шинжилгээ, холбогдох бусад баримт материалд үндэслэн Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, холбогдох төрийн байгууллагын өрийн удирдлагын талаарх чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг хамруулна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажилбаруудыг гүйцэтгэж, аудитын талбарын болон тайлагналын үе шатанд шаардлагатай мэргэжлийн, нотлох баримтаар баталгаажсан үндэслэлтэй санал, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Монгол Улсын 2019-2021 оны макро эдийн засгийн байдалд шинжилгээ хийж, дүгнэлт өгөх ¹	Өрийн удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 ² ,		Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/
2	Засгийн газрын 2019-2021 оны өрийн тогтвортой байдлын индикатор үзүүлэлтэд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах			Улсын өрийн аудитын удирдамж /АДБОУС 5400-5499/,

¹ 13.1. Өрийн удирдлагын бодлого, стратеги нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд, хамгийн бага зардлаар санхүүжүүлэх, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжихэд чиглэнэ

² энэ хуульд заасны дагуу стратегийн баримт бичгийн хэрэгжилтэд аудит хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх;

3	Монгол Улсын 2019-2021 оны зээлжих зэрэглэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах			Төрийн аудитын тухай хуулийн 15.1.22 заалт,
4	Засгийн газрын өрийн багцад нөлөөлөх хүчин зүйлс, зардал, эрсдэлд үзүүлэх нөлөөлөлд дүн шинжилгээ хийх	Өрийн удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийг 15.3 ³ ,	Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, Монгол Улсын 2019-2021 оны өрийн нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийх	Төсвийн тухай хуулийн 8.1, 7.4, 39.1, 14.1.6, 14.1.8, 61.1, 39.2, 39.3, 39.3.1, 39.3.2, 41.1, 41.4, 42.1, 42.2, 42.2.1, 42.2.2, 42.2.3, 42.3.1, 42.3.2, 42.3.3 заалтууд,
5	Өрийн дахин санхүүжилтийн зардалд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах			Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8, 4.1.8.а, 4.1.8.б, 6.1.4, 6.2 заалтууд,
6	Засгийн газрын өрийн удирдлагын стратегийг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж өгөх	Төрийн аудитын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 ⁴		Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.8, 8.1.1, 8.1.2, 8.1.6, 8.1.8, 8.2.1, 9.1.1, 9.1.3, 9.1.4, 9.1.5, 9.1.6, 11.2.1, 13.1, 13.2, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 15.1.1, 15.1.2, 15.2, 15.3, 15.4, 15.5, 18.1, 20.1, 21 дүгээр зүйл заалтууд,
		Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 ⁵ - т заасныг тус тус үндэслэнэ.	Цаашид Засгийн газрын өрийн удирдлагын стратегийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах	Валютын зохицуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл, 6.2, 7.3, 8.2, 8.5, 9.2, 10 дугаар зүйл, 14.1, 14.8, 15 дугаар зүйл, 17.2 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.5, 6.3, 7.1, 9.11, 10.15.2, 12.11 дэх заалтууд, Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг (УИХ-ын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 55 дугаар тогтоол), Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл (2019, 2020, 2021 он), Дээрх хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан холбогдох байгууллагын шийдвэр, бусад баримт бичиг

Нэмэлт шаардлага: Тухайн гүйцэтгэх ажлын хүрээнд шаардлагатай нэмэлт ажил гүйцэтгэх.

Гэрээт ажлын тайланд тавигдах шаардлага, хэмжээ, формат

- Үе шатны ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зай "single" үсгийн фонт Arial, хэмжээ 12-тай/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.
- Дагалдах материал болон үнэлгээний тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль тогтоомж, ном, хэвлэл, холбогдох бусад мэдээлэл зэрэг эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Шинжээч нь ажлын даалгаварт дурдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичнэ.

Шинжээчийн тайланд судалгааны явцад илэрсэн асуудлууд, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээний талаар зөвлөмж, саналыг боловсруулж тусгана.

Тайлан болон холбогдох судалгаа, тооцооллыг нотлох ажлын баримтыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

³ Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн ...тайланд төрийн аудитын төв байгууллага 04 дүгээр сарын 01-ний дотор аудит хийнэ;

⁴ Монгол Улсын Ерөнхий аудитор Засгийн газрын өрийн тайлан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлнэ;

⁵ Төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх

ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч нь аудитын баг болон Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллаж, аудитын үйл ажиллагаанд оролцоход аудитад хамрагдах байгууллагуудтай ашиг сонирхлын зөрчилгүй, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн дараах шаардлагыг хангасан хувь хүн, баг, хуулийн этгээд байна.

Дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан ажлын туршлагатай байх;
- Засгийн газрын өрийн нөхцөл байдал, өрийн удирдлагын стратегийн баримт бичигт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн дүгнэлт гаргасан туршлагатай байх;
- Санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн чиглэлээр нарийн мэргэшсэн, мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, дүн шинжилгээ хийж, таамаглал дэвшүүлэх чадвартай байх;
- Шинжээч нь шалгагдагч байгууллагад ажиллаж байгаагүй, тэдний ашиг сонирхол, нөлөөлөлд автахгүй байх.

Бүрдүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх гэрчилгээний хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх).

Дээрх шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбарыг ирүүлнэ.

ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцож гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.

ХЯНАСАН:

ГУРАВДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ЭНХБОЛД

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДОЛГОРСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР



Б.БОЛОРМАА

АУДИТОР



Э.УЯНГА

АУДИТОР



Ч.БАЯРМАА